# Гадаад валют арилжааны хяналтын систем

***/ХЭРЭГЛЭГЧИЙН ГАРЫН АВЛАГА/***

УЛААНБААТАР ХОТ

2020 он

# 1. ББСБ гадаад валют хувь хүнд зарах

**ХЭРЭГЛЭЭ**

Банк бус санхүүгийн байгууллагын гадаад валютын арилжааны мэдээллийн нэгдсэн систем бүрдүүлэх, харилцагчийг таньж мэдэх зорилгоор Монгол Улсын иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг төрийн мэдээлэл солилцооны “ХУР” системд нэвтэрч хурууны хээ болон хуулийн этгээдийн регистрийн дугаараар баталгаажуулах, валют арилжаа хийх тухай бүрд хэрэглэгчийн систем эсхүл цахим төлбөрийн баримтын системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг арилжаанд оролцогч хувь хүн, хуулийн этгээдэд хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээнэ.

**АЛХАМ-1**

**ХИЙХ ҮЙЛДЭЛ:**

ББСБ нь Цахим төлбөрийн баримтын систем **“Ebarimt.mn”-д** цахим тайлангийн систем ( **etax.mta.mn**)-ийн эрхээр нэвтрэн орно.

**Бизнес эрхлэгч** талбарыг сонгон харгалзах талбарт татвар төлөгчийн дугаар, нэвтрэх нэр, нууц үгээ оруулан нэвтрэх товчийг дарна.

***Зураг:1***




Цахим төлбөрийн баримтын системд нэвтэрсний дараа дараах цонх харагдана.

*Зураг: 2*




### АЛХАМ-2

## ХИЙХ ҮЙЛДЭЛ:

Цахим төлбөрийн баримтын систем /ebarimt.mn/- д нэвтрэн орж **БАРИМТ ШИВЭХ** товчийг даран **ХУВЬ ХҮН**-ийг чагтлаад “Бараа, ажил үйлчилгээ” оруулах хэсгийн ВАЛЮТ- аас тухайн валютын төрлийг сонгон ТОО ХЭМЖЭЭ болон НЭГЖ ҮНЭЭ оруулаад  товч дарна.

*Зураг№3*




Бараа ажил үйлчилгээг төлбөрийн баримт руу нэмэх товч дарснаар төлбөрийн баримт дараах загвараар үүснэ. Нэгээс дээш валют зарах тохиолдолд тоо хэмжээ хэсэгт зарах валютын тоог оруулан, нэгж үнээ тухайн өдрийн ханшаар бичиж бараа ажил үйлчилгээг төлбөрийн баримт руу нэмэх замаар үйлдэнэ. Алдаатай болон, буруу үйлдсэн гүйлгээ дээр дарахад энэ баримтыг устгах уу гэсэн диалог гарна.

***Зураг:4***




Баримт хэсэгт шивсэн баримт харагдах бөгөөд мэдээллээ шалгаж БАРИМТ ГАРГАХ товч дарна.

***Зураг:5***




**АЛХАМ-3**

**ХИЙХ ҮЙЛДЭЛ:**

1. Тухайн валютыг худалдан авч байгаа бол гарч ирэх “Валют арилжаа” цонхны ХУДАЛДАН АВАЛТ- ыг чагтлана. Зарж байгаа бол чагтлахгүй.
2. Тухайн иргэн нь гадаадын иргэн бол ГАДААДЫН ИРГЭН- ийг чагтлана.
3. Регистрийн дугаар оруулна.
4. Бэлнээр бол УНШУУЛАХ товч даран тухайн хувь хүний хурууны хээг уншуулан ГҮЙЛГЭЭ ХИЙХ товч дарна. Бэлэн бусаар бол ГҮЙЛГЭЭ ХИЙХ товч дарна.

Төлбөрийн баримт дахь гүйлгээний мэдээллээ нягтлаад төлбөрийн баримт гаргах товч дарж хурууны хээ уншуулах цонх нээгдэнэ.

***Зураг:6***




**АЛХАМ-4** *Зураг№7*




**ХИЙХ ҮЙЛДЭЛ:**

Шивсэн баримтаа цахим шуудангаар илгээх болон хэвлэх боломжтой. Хурууны хээ уншуулж хур системээс баталгаажуулснаар тухайн иргэний ebarimt д баримт автоматаар бүртгэгдэнэ. Ebarimt системд бүртгэлгүй бол төлбөрийн баримтыг иргэнд хэвлэж өгнө.

**ГАРАХ ҮР ДҮН:**

ТӨЛБӨРИЙН БАРИМТУУД цэсийн "Ebarimt-р хийгдсэн баримтын жагсаалт"- ын таны шивсэн баримт нэмэгдэнэ.

## 2. ББСБ гадаад валют хувь хүнээс худалдан авах

**АЛХАМ-1**

ББСБ иргэнээс гадаад валют авах үед ebarimt.mn ХУВЬ ХҮНД цэсээр баримт шивнэ.

**Хийх үйлдэл:**

- Бараа, ажил үйлчилгээ оруулах цэсийн валют цэсээс гадаад валютаа сонгоод тоо ширхэг, нэгж үнэ оруулна.
- Худалдан авалт гэсэн сонголт хийнэ.
- Иргэний регистрийн дугаарыг бүртгэж, хурууны хээг уншуулж Хур системээс шалгана.
- Хур системд бүртгэлгүй бол төлбөрийн баримтыг хэвлэн өгнө.
- Хур системд бүртгэлтэй бол төлбөрийн баримт иргэний ибаримтад автоматаар бүртгэгдэнэ.
- Хур системд бүртгэлтэй боловч ибаримт системд бүртгэлгүй бол төлбөрийн баримтыг хэвлэн өгнө.

***Зураг№8***




## 3. ББСБ гадаад валют ААНБ-д худалдах, худалдан авах

Цахим төлбөрийн баримтын систем /ebarimt.mn/- д нэвтрэн орж **БАРИМТ ШИВЭХ** товчийг даран **БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД**-ийг чагтлаад Худалдан авагчийн регистрийн дугаарийг бичихэд

төлбөрийн баримтын хэсэгт худалдан авагчийн мэдээлэл бөглөгдөнө. Зарсан валют ААН хувьд борлуулалт болно.

**АЛХАМ:1** ***Зураг№9***




**АЛХАМ:2**

**ХИЙХ ҮЙЛДЭЛ:**

"Бараа, ажил үйлчилгээ" оруулах хэсгийн ВАЛЮТ- аас тухайн валютын төрлийг сонгон ТОО ХЭМЖЭЭ болон НЭГЖ ҮНЭЭ оруулаад  товч дарна. ***Зураг№10***




**АЛХАМ-3**

**ХИЙХ ҮЙЛДЭЛ:**

1. Мэдээллээ шалгаж **БАРИМТ ГАРГАХ** товч дарахад "Валют арилжаа" цонх гарч ирэх бөгөөд тухайн валютыг худалдан авч байгаа бол гарч ирэх **ХУДАЛДАН АВАЛТ**- ыг чагтлана. Зарж байгаа бол чагтлахгүй.
2. Бэлэн болон Бэлэн бус-ийг сонгон **ГҮЙЛГЭЭ ХИЙХ** товч дарна. ***Зураг№11***




*Зураг№12*

**АЛХАМ-4**

**ХИЙХ ҮЙЛДЭЛ:**

Шивсэн баримтаа цахим шуудангаар илгээх болон хэвлэх боломжтой.




**ГАРАХ ҮР ДҮН:**

ТӨЛБӨРИЙН БАРИМТУУД цэсийн “Ebarimt-р хийгдсэн баримтын жагсаалт”- ын -д таны шивсэн баримт нэмэгдэнэ.

## 4. ББСБ валют Гадаад иргэнд зарах

ББСБ нь иргэнд гадаад валют зарахад ebarimt.mn ХУВЬ ХҮНД цэсээр орж баримт шивнэ.

Бараа, ажил үйлчилгээ оруулах цэсийн валют цэсээс ГАДААД ВАЛЮТАА сонгоод тоо ширхэг, нэгж үнэ оруулна.

Гадаад иргэн бол гадаад иргэн сонголтыг хийж, паспортын дугаар оруулна.

*Зураг№13*




## 5. ББСБ валют гадаад иргэнээс  худалдан авах

ББСБ иргэнээс гадаад валют авах үед ebarimt.mn ХУВЬ ХҮНД цэсээр баримт шивнэ.

Бараа, ажил үйлчилгээ оруулах цэсийн валют цэсээс гадаад валютаа сонгоод тоо ширхэг, нэгж үнэ оруулна.

Худалдан авалт гэсэн сонголт хийнэ.

Гадаад иргэн гэсэн сонголт хийнэ. ***Зураг:14***



## 6. Бэлэн бэлэн бусаар төлбөр тооцоо хийх

**АЛХАМ:1**

**Хийх үйлдэл: Бэлнээр төлбөр тооцоо хийх үед:**
ББСБ иргэнээс гадаад валют авах үед ebarimt.mn ХУВЬ ХҮНД цэсээр баримт шивнэ.

Бараа, ажил үйлчилгээ оруулах цэсийн валют цэсээс гадаад валютаа сонгоод тоо ширхэг, нэгж үнэ оруулна.

Худалдан авалт гэсэн сонголт хийнэ.

Иргэний регистрийн дугаарыг бүртгэж, хурууны хээг уншуулж Хур системээс шалгана.

Хур системд бүртгэлгүй бол төлбөрийн баримтыг хэвлэн өгнө.

Хур системд бүртгэлтэй бол төлбөрийн баримт иргэний ибаримтад автоматаар бүртгэгдэнэ.

Хур системд бүртгэлтэй боловч ибаримт системд бүртгэлгүй бол төлбөрийн баримтыг хэвлэн өгнө.

*Зураг:15*




**АЛХАМ-2**

**Хийх үйлдэл:Бэлэн бусаар төлбөр тооцоо хийх үед:**

Иргэн, ААН бэлэн бусаар төлбөр тооцоо хийх үед бэлэн бус гэсэн талбар байх ба баримт тухайн иргэний имэйл хаягт ирнэ. Эсвэл PDF файлаар хэвлэх боломжтой.

*Зураг:16*




## 7. Тайлан

Тайланг ББСБ тус бүрээр бөөн дүнгээр нэгтгэл байдлаар авна. Задаргаа гарах боломжгүй.

Тухайн банк бус санхүүгийн байгууллага борлуулалт худалдан авалтын мэдээллээ дараах байдлаар харах боломжтой.

*Зураг:17*



EBARIMT-Р ХИЙГДСЭН БАРИМТЫН ЖАГСААЛТ

ТТД: ТТД | Жил: 2020 | Сар: 7 | Борлуулалт | Харах

Баримт | Засагдсан баримт | Зөрчилтэй баримт | Баталгаажаагүй буцаалт 1

| № | ДДТД | Огноо | Баримт шивсэн хэрэглэгч | Харилцагч | НӨАТ | Нийт дүн | Төлөв |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 000099119911000200723000001482834 | 2020-07-23 | | ТЕСТИЙН ХЭРЭГЛЭГЧ 2 (99119912) | 0.00₮ | 287,560.00₮ | Илгээгдсэн |
| 2 | 000099119911000200723000001458658 | 2020-07-23 | | ТЕСТИЙН ХЭРЭГЛЭГЧ 2 (99119912) | 0.00₮ | 500,000.00₮ | Илгээгдсэн |
| 3 | 000099119911000200721000001396082 | 2020-07-21 | | ЭЦСИЙН ХЭРЭГЛЭГЧ (1000000) | 0.00₮ | 100.00₮ | Илгээгдсэн |
| 4 | 000099119911000200721000001395995 | 2020-07-21 | | ТЕСТИЙН ХЭРЭГЛЭГЧ 2 (99119912) | 0.00₮ | 100,000.00₮ | Илгээгдсэн |
| 5 | 000099119911000200717000001318427 | 2020-07-17 | | ТЕСТИЙН ХЭРЭГЛЭГЧ 2 (99119912) | 0.00₮ | 5,000,000.00₮ | Илгээгдсэн |
| 6 | 000099119911000200716000001274930 | 2020-07-16 | | ТЕСТИЙН ХЭРЭГЛЭГЧ 2 (99119912) | 0.00₮ | 500,000.00₮ | Илгээгдсэн |
| 7 | 000099119911000200708000001146091 | 2020-07-08 | | ТЕСТИЙН ХЭРЭГЛЭГЧ 2 (99119912) | 0.00₮ | 2,500.00₮ | Илгээгдсэн |
| 8 | 000099119911000200708000001132872 | 2020-07-08 | | ТЕСТИЙН ХЭРЭГЛЭГЧ | 0.00₮ | 400,000.00₮ | Илгээгдсэн |